

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2013-05-15/

Ажлын хэсгийн 32 дугаар хуралдаан 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 16 цагт Уул уурхайн яамны хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Отгочулуу, мөн яамны төсөл хариуцсан мэргэжилтэн Б.Хулан, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Ашигт малтмалын газрын Уул уурхайн хэлтсийн дарга С.Баттулга, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэргэжилтэн С.Баярцэцэг, Татварын ерөнхий газрын байцаагч Д.Энхтуяа, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Оюу толгой ХХК-ийн олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Монголын геологийн холбооны ерөнхийлөгч Т.Мөнхбат, Хүний эрх хөгжлийн төвийн тэргүүн Г.Уранцоож, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагай уул уурхайн санаачилга ТББ-ын тэргүүн Л.Долгормаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 17 гишүүн оролцож ирц 55 хувьтай байв.

Мөн хуралдаанд Адам Смит төслийн сургалтын зөвлөх хатагтай Эмма Ирвин, менежер П.Оюунбилэг, орчуулагч Г.Базар, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хурлыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нээж үг хэлэв.

Ш.Цолмон: Өнөөдрийн хуралдааныг Уул уурхайн яамны газрын дарга Ч.Отгочулуу удирдан явуулах байсан боловч хурал давхацсан тул намайг хурлаа эхлүүлж бай гэлээ. Иймд хэдүүлээ хурлаа эхэлж байх уу. Хурлын ирц 33 гишүүнээс 17 ирсэн бөгөөд Л.Гансүх дарга гадуур ажилтай, Газрын тосны газрын Б.Оюун мөн ажилтай тул ирж амжихгүйгээ албан ёсоор мэдэгдсэн. Ингээд хурлаа эхлэх үү. Татгалзаж байгаа хүн байна уу.

Гишүүд: Хурлаа эхлүүлэхийг дэмжиж байна.

Ш.Цолмон: Манай өнөөдрийн хуралд Адам Смит төслийн сургалтын зөвлөх хатагтай Эмма Ирвин сургалтын хэрэгцээний талаар дэлгэрэнгүй танилцуулга хийнэ. Дараа нь 2013 оны 5 дугаар сард Сиднэй хотод зохиогдох олон улсын бага хуралд оролцох Монголын төлөөлөгчдийн бэлтгэл ажлын талаар товчхон мэдээлэл хийх болон бусад асуудал гэсэн гурван асуудлын талаар ярилцах болно. Хөтөлбөрийн талаар нэмж хасах санал байна уу. Байхгүй бол хатагтай Эмма Ирвиныг урьж байна.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын ажлын хэрэгцээний судалгааны дүн, сургалтын төлөвлөгөөний төсөл

Хатагтай Эмма: Та бүхэнтэй дахин уулзаж байгаадаа баяртай байна. Би өнөөдөр хийх танилцуулгаа англи хэл дээр хийж, орчуулгатай явах болно. Дараагийн удаад би монгол хэлээ сайжруулаад дараагийн удаа монгол хэлээр ярихыг хичээх болно. Илтгэлээ би англи хэлээр удаан ярих болно. Тэгээд орчуулга давхар явагдах болно. Энэхүү илтгэлээ хэдэн хэсэгт хуваан тавих болно. Үүнд **нэгдүгээрт**, төслийн талаар мэдээлэл өгөх болно. **хоёрдугаарт** 2012 онд танай оронд ирж хийсэн судалгаан дээр үндэслэн сургалтын зорилтот хэсгүүд болон зөвлөмжүүд гэсэн үндсэн хэсгүүдээр хувааж ярих болно. Мөн одоо хийж байгаа айлчлалаар хийсэн дүгнэлтүүд байгаа. Сургалтын талаар би та бүхэнд дэлгэрэнгүй ярих бөгөөд үүний дараа та бүхний дунд сургалтын сонголтууд болон боломжуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх болно. За одоо илтгэлдээ орё.

Адам Смитийн зүгээр 6 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа. Эдгээрийн нэг нь бол сургалтын хөтөлбөр байгаа юм. Энэ сургалтын хөтөлбөр маань 2 хэсэгт хуваагдаж байгаа. **Нэгдүгээрт**, сургалтын хэрэгцээний үнэлгээ **хоёрдугаарт** санал болгож буй сургалтын багцийн талаар явуулах юм. Чадавхи болон сургалтын хэрэгцээний судалгааг 2012 онд Улаанбаатар болон Өмнөговь аймагт ажиллаж олон хүмүүстэй уулзсаны үр дүнд хийсэн бөгөөд зорилтот бүлгүүдийг тодорхойлсон байгаа. Мөн зорилтот бүлгүүдээ Засгийн газрын байгууллагууд, компаниуд, Иргэний нийгмийн байгууллага гэсэн үндсэн 3 чиглэлээр тодорхойлж, тус бүрт нь зөвлөмж бичсэг байгаа. /илтгэлийг хавсаргав/

Төсөл маань нэг хэсэг үйл ажиллагаа явуулахгүй завсарласан байсан. Одоо үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилготой байгаа ба үүнд, ОУИТБ-ийн тухай хууль болон сургалтыг асуудал байгаа юм. Энэ удаагийн айлчлалаараа би сургалтын асуудлыг шийдвэрлэхээр ирсэн байгаа. Олон талт оролцогч талуудад ямар, ямар төрлийн сургалтын хэрэгцээ байгаа юм бэ, ямар сонголтууд байна гэдэг талаар ярилцаж зөвшилцөлд хүрэх зорилготой байна. Та бүхэнд зорилтот бүлгүүдийн талаарх материалыг тараасан байгаа. Энэ талаар асуух асуулт байвал асууж болно.

Би үнэлгээг хийх явцад сургалтын хэрэгцээг 2 хэсэгт хувааж авч үзсэн. Улаанбаатараас гадна, аймаг сумын түвшинд авч үзэхийг зорьсон. Гол зөвлөмжүүд нь үндэсний түвшинд болон орон нутгийн түвшинд гэсэн 2 үндсэн хэсэгт хуваагдаж байгаа. Эдгээр нь 1 дүгээр сард хийсэн миний тайлангийн товчхон хэсэг нь байгаа. Хэрвээ дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл тайлангаас харж болно. Орон нутгийн хэмжээнд авч үзвэл ОУИТБС-ийн талаар хүмүүс мэдээлэл дутмаг байна гэж үзсэн. Мөн үндэсний хэмжээнд мэдээлэл хангалттай байгаа ч орон нутгийн түвшинд очиход мэдээлэл хомс байна. Компаниудын хувьд ОУИТБС-ийн тайлангийн маягтыг хэрхэн бөглөх вэ гэдэг дээр мэдээлэл муу, хэдхэн цөөхөн компаниуд л тайланд хамрагдаж байна. ОУИТБС-ийн зорилгын талаар сайн ойлголтогтой байна. ОУИТБС-д хамрагдаж байгаа компаниудын тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа тул компаниудын мэдлэгийг сайжруулах хэрэгтэй байна. Тайланд хамрагдсан компаниудын тоо энэ жил 1500-д хүрсэн байна.

Иргэний нийгмийн байгууллагуудын ойлголтуудыг сайжруулах шаардлагатай байна. Үүнээс гадна иргэний нийгмийн байгууллагуудын хувьд жигд нөлөөлөлтэй байх, тэдний чадавхийг сайжруулах сургалт зайлшгүй

шаардлагатай байна гэж үзсэн. Та бүхэнд тараасан материалын талаар тодруулах зүйл байвал асууж болно.

Э.Сумъяа: Хуучин мэдээлэл дээр тулгуурласан байна. Монгол улсын өнөөгийн байдал, иргэний нийгмийн байгууллагын талаар судлаагүй байна. 2011 оны таны явуулсан материал, асуудал дээр бид ярилцаж байсан, маргаж байсан. Өнөөдөр Монгол улс уул уурхайн сайдтай, уул уурхайн яамтай болсон. Өнөөдөр Уул уурхайн яаман дээр энэ асуудлыг хариуцсан 2 газар ажиллаж байна. ОУИТБС-ийн хууль тогтоомжийн асуудлыг хариуцсан газар нөгөө талаар бодлогын зохицуулалтын газар ажиллаж байна. Манай Засгийн газар энэ тал дээр нилээд их санаа тавьж ажиллаж байгаа. Үүний үр дүнд өнөөдөр тайлан гаргасан компаниуд 1500 хүрээд байна. Энэ нь нөгөө тал дээр хэрэгцээ болоод байгаа. Өмнө нь ганцхан Засгийн газар хариуцаж байсан бол одоо бие даасан 3 субъект хамтран тал талаасаа санал оруулж, асуудлаа хэлэлцэж шийдвэрлэдэг болоод байна. Засгийн газар, компани, иргэний нийгмийн байгууллагууд өөрсдийн төлөөлөлийг томилно. Хурлаа ч гэсэн харилцан удирдаад явж байгаа. Өөрөөр хэлбэл санаачилга гэдэг юм хэрэгжээд эхэлчихсэн юм. Бидэн өнөөдөр хэрэгцээнд суурилсан зөвлөмж хэрэгтэй байна. Үүнийг анхаар үзээч. Би өөрийнхөө бодлыг хэллээ.

Хатагтай Эмма: Санал хэлсэнд маш их баярлалаа.

Н.Алгаа: Миний бодлоор бол зөвлөмж маш сайн болсон байна. Олон хүмүүстэй уулзаад түүнийхээ үндсэн дээр зөвлөмж гаргасан байна гэж ойлгож байна. Хуучин бол маягт энэ тэр бөглөөд явдаг байсан одоо бол зорилтот бүлгүүдээ тодорхойлоод хэрэгжиж байгаа учраас би үүнийг муу гэж хэлэхгүй ээ. Өнөөдөр компаниуд, ТББ-ууд болон Засгийн газар энэ асуудлыг мэдэхгүй байгаа. Иймээс зорилтот бүлгүүдийг оролцогч тал бүрээр нь тодорхойлсон нь сайн болсон байна. Төрийн байгууллагуудад энэ асуудлыг хариуцаж байгаа мэргэжилтнүүдэд сургалт явуулах нь зайлшгүй хэрэгтэй. Манай салбарын зарим компаниуд ганцхан тайлан гаргахаас өөр юм мэдэхгүй байгаа. Иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн энд оролцож байгаа нь энэ талаар мэддэг байдаг боловч оролцоогүй нь юу ч мэдэхгүй л байгаа. Иймд энэ 12 сургалтуудаа нилээн судалж нөхцөл байдалтай танилцсаны үндсэн дээр гаргасан байх гэж бодож байна.

Н.Баярсайхан: Нилээд мэдээлэл нь 2011 оных байна л даа. Нөлөөлөл гэдгийг 2011 онд харж байснаас өнөөдөр арай өөрөөр харах шаардлага гараад байна. Жишээлбэл ОУИТБС-ийн тайлангийн мэдээллийг цааш нь яаж ашиглах вэ? Тухайлбал, жилийн төсөв, улсын төсөв зохиоходоо энэ мэдээллийг яаж ашиглах вэ гэх мэтчилэн тайланг яаж гаргах вэ гэж ярих хэрэгцээ болоод байна. Орон нутгийн түвшинд мөн бүлэг байгуулагдаж байгаа. Тэд нар байгуулагдаад цаашид юу хийх юм бэ, яаж байгуулагдах юм гэдэг нь тодорхойгүй байсаар ирсэн. Засгийн газрын 80 дугаар тогтоол гэж байсан, дараа нь 222 дугаар тогтоол гэж гарсан. Тэгэхээр энэ шинэ нөхцөл байдалд нийцсэн сургалтын хэрэгцээ хэрэгтэй байна. Саяхан манай ТАН эвслийн хурал дээр манай гишүүдээс санал гаргаж байсан. Тухайлбал хөрөнгийн бирж дээр босгож байгаа хөрөнгийг бид яаж хянах вэ, хянаж чадах уу гэсэн асуудал гарч байсан гэх мэтчилэн шинэ хэрэгцээг харж үзэх шаардлагатай байх гэж бодож байна. Энэ жил ирээд манай иргэний нийгмийнхэнтэй уулзаагүй байгаа. Гэхдээ энэ төлөвлөгөө бол их сайн болсон байна. Зорилтот бүлгүүдэд чиглэсэн байдлаар мөн байж болох хувилбаруудыг оруулсан байгаа нь сайн болсон байна.

Хатагтай Эмма: Санал хэлсэнд маш их баярлалаа.

Х.Лхамаа: Зорилтот бүлгүүд дээр хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хамруулах гэсэн санал байна. Олон нийтэд мэдээллийг түгээх тал дээр үндсэн ойлголт өгөхөд хэрэгтэй болов уу гэж бодож байна.

Хатагтай Эмма: Илтгэлийн энэ хэсгийг та бүхний гаргасан саналуудтай хамтад нь дүгнээд хэлчихье гэж бодож байна. Та бүхний хэлсэн саналууд маш их үнэтэй, үнэний ортой байна. Маш их баярлалаа гэж хэлмээр байна. Түүнээс гадна миний хийсэн үнэлгээ маань ерөнхий хүрээнд хийгдсэн байгаа. Энэ нь ямар хэрэгцээ байна вэ гэдгийг тодорхойлж гаргаж ирсэн байгаа. Би энэ удаагийн айлчлалаараа 2011 оны үнэлгээнээс гарсан дүгнэлтүүд дээр анхаарахаас илүү 2012 онд ямар нөхцөл байдал гарч ирсэн, ямар өөрчлөлт байна вэ гэдгийг хараад сургалт болон бусад үйл ажиллагааны талаар юу боломжтой байна гэдэг дээр бодит хувилбаруудыг гаргаж ирсэн байгаа.

2013 оны 5 сард буюу миний одоогийн хийж байгаа айлчлалаар ямар өөрчлөлт гарсан талаар ярихыг хүсэж байна. Нэгдүгээрт, 2011 оны судалгаа явуулж байх үеэс ахиц гарсан байна. Манай санаачилгын гол зорилго, ил тод байдлын талаар мэдээллийг олон нийтэд таниулах хэрэгтэй юм байна гэж үзсэн. Хоёрдугаарт, ОУИТБС-ийн талаарх Монголд юу хийх хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлох, гуравдугаарт ОУИТБС-ийн тухай хуулийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэх хэрэгтэй юм байна гэж үзсэн. Үүнээс гадна тайлангаа хэрхэн ашиглах вэ, тайлангаас гарч ирж байгаа мэдээллүүдийг иргэдэд хэрхэн үр дүнтэй ашиглах боломжоор хангах вэ гэдэг асуудлууд гарч ирж байна. Үүнээс гадна ирэх 7 хоногт Сиднэйд болох бага хурлаар ОУИТБС-ийн тогтолцооны талаар авч хэлэлцэх байгаа. Үүний үр дүнд санаачилгын ерөнхий тогтолцоонууд тодорхой болно. Үүнээс гадна миний дурдсан 12 төрлийн сургалтыг хэрхэн явуулах талаар сонголтуудыг гаргасан байгаа.

Энэ удаагийн айлчлалаар хийсэн хамгийн чухал зүйл бол 12 төрлийн сургалтын багцууд байгаа. Үүнийг 2011-2012 онд явуулсан үр дүн болон 2013 онд хийсэн ажлын үр дүн тодорхойлогдох юм. Эхлээд урт жагсаалт гаргаад түүнээсээ хамгийн хэрэгцээтэй гэсэн сургалтаа сонгож авсан байгаа. Үүнийг ажлын албанаас батлах ёстой.

Ч.Отгочулуу: Энэ асуудлаа дуусгаад дараагийн асуудал руу оръё.

Хатагтай Эмма: Та бүхний тараасан материал дээр 12 сургалтын 3 багц сургалтыг гаргаж ирсэн байгаа. Үүнийг яагаад хэрэгжүүлэх санал болгож байгаа вэ гэвэл зорилтот бүлгүүд болон хэрэгцээний хувьд илүү ач холбогдолтой. Үүнээс гадна цаашдаа урт хугацаанд тогтвортой үр дүн авчрах юм байна гэж үзсэн. Үүнд: “Олон нийтийн харилцаа, хэлэлцээ зөвшилцөлд хүрэх” “Сургагч багшийн сургалт”, “ОУИТБС-ын хэрэгжилт” гэсэн 3 төрлийн сургалт байгаа. /сургалтын төлөвлөгөөг хавсаргав/

Бид энэ сургалтуудыг одоогийн гарч байгаа өөрчлөлтүүдэд нийцсэн сургалт болно гэж үзэж байгаа. Гэхдээ энэ сургалтын багцийг та бүхэн дэмжээд батлах ёстой. Мөн сургалтын багц дээр санаа нэгдэхгүй байгаа юм уу нэмэлт байгаа бол одоо хэлэлцэх хэрэгтэй байна. 3 багцийг зэрэг хэрэгжүүлэх юм.

Б.Дэлгэрмаа: 12 сургалт гэдэг нь 12 өдрийн сургалт гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл 1 өдрийн сургалтыг 1 сургалт гэж үзнэ.

Ш.Цолмон: Хатагтай Эмматай бид сургалтын талаар нилээд их зөвшилцсөн байгаа. Сургалтын хэрэгцээ бол маш их байгаа. Гэхдээ тэр болгоныг хангах боломжгүй учраас 3 багц хувилбарыг гаргаж боловсруулсан. Энэ нь хөрөнгө мөнгөндөө ч гэсэн боломжийн байгаа юм. Сургалт батлагдсаны дараа сургалтын нарийн хөтөлбөрүүд гарна. Ажлын албаны зүгээс дэмжиж байгаа. Хөдөө орон нутагт хийх сургалтыг Дэлхийн банкны санхүүжилтээр хийх боломж бидэнд байгаа.

Н.Баярсайхан: Сургалтын зорилтот бүлгүүд сайн болсон байна. Нийтдээ 85000 еврог хэдэн хүнд сургалт хийхэд л зарцуулах юм байна. Ер нь хүнийхээ тоог нэмэх ч юм уу эсвэл сургалтаа нэмвэл яасан яаж байна гэсэн санааг хэлэх гэсэн юм. Энэ дээр ямар харьцуулалт хийсэн юм бол. Үр ашиг талаас нь харвал.

Хатагтай Эмма: Эхний сургалтын хувьд хүний тоог 60 хүн ч болгох боломжтой. Гэхдээ бид сургалтыг үр ашигтай байлгах үүднээс сургалтад хамрагдах хүний тоог хязгаарлагдмал цөөн тавьсан байгаа. Нэг удаа 60 хүнд хэр зэрэг үр дүнтэй байх бол гэдэг нь эргэлзээтэй.

Н.Баярсайхан: Сургалтын давтамжийг нэмэх боломж байгаа болов уу.

Хатагтай Эмма: Сургалтуудаа одоо хийчихвэл дараа нь хөрөнгө мөнгө олдвол дахин хийх боломжтой. Энэхүү сургалтын хуваарийг та бүхэн хэлэлцээд дараа нь хариу өгч болно.

Ч.Отгочулуу: Би яаман дээр хуралтай байгаад хоцорчихлоо. Одоо эргээд 6 цагаас дахин хуралд орох ёстой. Би сургалтыг дэмжиж байна. Тэгээд сургалтын талаар өөр санал хэлэх хүн байвал хэлчих.

Э.Сумъяа: Та нар хурлын байраар хангана гэхихээд яаруулаад байж болохгүй ш дээ. Ажлын хэсгүүд дандаа хэлэлцэж хуралддаг.

Ч.Отгочулуу: Энэ өрөөнд хуралдаж болно. Би гол нь хуралтай юм.

Н.Алгаа: Тэгвэл та эрхээ шилжүүлээд хуралдаа явж болно. Бид хурлаа үргэлжлүүлэе гэсэн санааг Сумъяа гуай хэлж байна.

Ч.Отгочулуу: Одоо тэгвэл сургалтын асуудлаа жаахан завсарлаад, ирэх 7 хоногт Австралид хийх сайдын айлчлалын талаар товч мэдээлэл хүргэе.

Хатагтай Эмма: Энэ асуудал 2 минутын дараа дуусна. За тэгье. Түр хүлээж байя.

Ш.Цолмон: Одоо хэдүүлээ сургалтынхаа асуудалд эргэж оръё. Сургалтын тоо хэд байх вэ? Ямар ямар сургалтуудыг явуулах талаар хэлэлцэх ёстой. Сургалтын тооны хувьд бол Европын банк 12 байхаар төлөвлөсөн байгаа энэ байр сууриа баримтлах бодолтой байгаа болов уу. Хураангуй жагсаалтаас түүвэрлэж зөвшилцсөн байгаа.

Э.Сумъяа: Надад нэг асуулт байна. Сургагч багш гэдэг дээр дандаа монгол хүн байгаа юм шиг байна. Энэ талаар

Хатагтай Эмма: Сургалтыг сургалт явуулах хангалттай чадвартай монгол хүн хийх нь илүү үр дүнтэй гэж үзсэн. Тухайлбал над шиг нэг гадаад хүн ирээд сургалт явуулснаас монгол хүн өөрөө арга барилаа олж, туршлагажаад сургалтаа заагаад явах нь илүү үр дүнтэй юм гэж бид шийдсэн юм,

Оюунбилэг: Бид үнэлгээ хийгээд явж байхад энэ сургалт нь сэдвийнхээ хувьд заавал гадаад хүн заагаад байх шаардлагагүй юм байна гэж ойлгосон.

Э.Сумъяа: 2011 онд бид хүсэхдээ сургалтын модуль бий болгож өгөөч ээ гэж хүссэн. Одоо энэ асуудал хэвээрээ л байгаад байх юм. Энэ ямар учиртай юм бол оо

Хатагтай Эмма: 2011 онд бид сургалтыг ямар хэлбэрээр явуулах вэ гэсэн ерөнхий төлөвлөгөө гарсан байсан. Түүнээс өөр төлөвлөгөөг шинэ өнцгөөс харж хийх хэрэгтэй гэсэн учраас бид энэ төлөвлөгөөг боловсруулсан. Сургагч багш нар нар нь монгол хүн байгаад түүнд сургалтын материалаа боловсруулах ур чадвар олгоё гэж шийдсэн. Гаднын хүн сургалтын материал бэлдэж өгөхөөсөө илүүтэйгээр сургагч багш нар өөрсдөө сургалтын материалаа бэлдэх чадавхитай болгох зорилготой юм.

Түүнээс гадна сургагч багшийн дадлага ажлын хэсэг гэж байгаа. Үүн дээр сургагч багш өөрөө сургалтын бодлого боловсруулах дадлага ажил хийх болно. Практик дадлага ажлын хүрээнд яг юуг яаж хийх вэ гэдгээ ярилцаж хийнэ. Сургалтанд оролцож байгаа хүмүүс ажлын хэсэг байгуулаад цаашид сургалтын үйл ажиллагаа явуулах боломжтой юм.

Н.Алгаа: Сургагч багшийг өөрийн байгууллагад найдвартай ажиллах хүнээр тавих хэрэгтэй. Тухайлбал манайхаас 2, Иргэний нийгмийн байгууллагаас 2 ч гэх юм уу. Тэгэхгүй нөгөө сургагч багш болсон хүн нь ажлаасаа гарах энэ тэр гээд алга болоод өгвөл сургалт үр дүнгүй болно.

Б.Баярмаа: Сургагч багшийн тоог 15 ч юм уу болгож тоог нэмэх хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: Сургагч багшийн тоог 15 болгомоор байгаа юм. 10 хүн 15 хүнд сургалт хийхэд ялгаа байна уу.

Хатагтай Эмма: Та бүхэн ямар төрлийн сургалт хийх болон хэдэн хүн оролцуулахаа тохироод шийдвэр гаргаад бидэнд өгч болно. Адам Смитийн захирал Жоннотан Сиднэйн хурлын дараа Монголд ирнэ. Та бүхэн сонгосон сургалтын багцаа түүнтэй хэлэлцээд ямар төрлийн сургалтыг ямар төсөвтэйгээр хийх вэ гэдгээ шийдвэрлэх юм.

Н.Алгаа: Компаниудад зориулсан 2 сургалтын нэгийг нь хасаад оронд нь хэвлэл мэдээллийн ажилтнуудын сургалт хийж болох юм. 12 гэдэгт чинь хэдэн сургалт байх вэ?

Хатагтай Эмма: 1 өдрийн сургалтыг 1 сургалт гэж тооцож байгаа. Өөрөөр хэлбэл 5 өдрийн сургалт нь 5 сургалт гэсэн үг юм. Энэ нь төсөвөө багцаалж хийсэн юм. Жаахан өөрчлөлт оруулж болох юм.

Н.Алгаа: энэ 3 багц чинь нийлээд 12 сургалт гэж ойлгож болох уу?

Хатагтай Эмма: Тиймээ, 3 багц нийтдээ 12 сургалт болох юм.

Н.Баярсайхан: 12 сургалт байна аа гэхихээд хоногоо заагаагүй байна.

Э.Сумъяа: Энэ бол мөнгө угаах нэг арга юм.

Н.Алгаа: Би бол тэгэж үзэхгүй байна. Бид нар авч ирсэн мэдлэгийг олж аваад хэрэгжүүлж чадахгүй байна. Засгийн газар бол зөвхөн зөвлөмж өгөх л эрхтэй. Бид энэ сургалтыг авахгүй бол бидний л хохь болно. Ялангуяа бид сургагч багшаа бэлдүүлээд, тэр мэдлэгээ цааш нь авч явах юм бол 85 000 евро үр дүнтэй болно гэсэн үг. Түүнээс биш бид мөнгийг нь тоолоод их бага байна гэх асуудал биш тэр өгч байгаа мэдлэгийг нь олж аваад эндээ нутагшуулах хэрэгтэй байна.

Т.Мөнхбат: Багш нар маань сайн багш байх ёстой байна. 5 хоногийн дотор хангалттай мэдлэг хуримтлуулж чадах уу? Зүгээр багш гээд асуудлаа шийдэж чадахгүй байх вий? 5 өдөр бол мэргэжилтэн бэлдэхэд хангалттай байдаг, сургагч багш бэлдэхэд ямар бол?

Н.Баярсайхан: 5 хоног бол хангалттай хугацаатай юм.

Д.Цэрэнжав: Надад нэг санал байна. Бидний хувьд ил тод байдлын санаачилгын хувьд мэдлэг ойлголт хангалтгүй гэсэн үндэслэлээр сургалт зайлшгүй хэрэгтэй гэсэн юм байна. Бидний дундаас сургагч багш нар гарах юм байна. Бид нэгнийгээ сургах юм байна. Үүний оронд семинар байдлаар хийвэл илүү үр дүнтэй байх юм биш үү. Тухайлбал, тайлангийн маягтаа яаж бөглөх вэ, тайланг цааш нь түгээж хүргэх вэ ч юм уу.

Н.Алгаа: Энд хамгийн гол семинар нь алга байна. Өөрөөр хэлбэл тус тусад нь хийгээд дараа нь нэгтгээд нэг ойлголтод хүрэх семинар хэрэгтэй байна. Үндэсний хэмжээний олон талуудыг оролцуулсан байх ёстой.

Хатагтай Эмма: Таны саналыг оруулж болно.

Э.Сумъяа: Би эсэргүүцээд байгаагийн гол шалтгаан нь компаниуд юу ч мэдэхгүй байна гээд байсан. Гэтэл сургалт хэрэггүй гээд байх юм.

н.Уранцоож: Сургалт хаана ч шаардлагатай. Ялангуяа хөдөө орон нутагт шаардлагатай байгаа.

Э.Сумъяа: эсэргүүцэж байна гэж тэмдэглээрэй.

2. ХЭЛЭЛЦСЭН нь: Сиднэй зохиогдох ОУИТБС-ийн 6 дугаар бага хуралд оролцох Монголын төлөөлөгчдийн бэлтгэл ажлын тухай

Ш.Цолмон: Та бүхэнд бага хурлын хөтөлбөрийн тараасан байгаа тул товчхон мэдээлэл өгье. Энэ удаагийн ОУИТБС-ийн бага хурал Австралийн Сиднэй хотод зохиогдох ба уг хурал нь 2 жилд 1 удаа болдог юм. Бага хуралд нийтдээ 1000 гаруй төлөөлөгч оролцохоос манай улсаас 20 гаруй хүн энэ хуралд оролцох гэж байгаа. Бага хурлын үеэр хэд хэдэн төрлийн уулзалтууд болно.

Тухайлбал: Харилцааны сургалтын семинар, Зохицуулагчдын уулзалт гэх мэт. Хамгийн том зүйл бол манай улсын Уул уурхайн сайд Ганхуяг бага хуралд оролцохоос гадна Австралид албан ёсны ажлын айлчлал хийж, албаны хүмүүстэй уулзаж хамтын ажиллагааны талаар ярилцах төлөвлөгөөтэй байгаа. Мөн хатагтай Клэйр Шорттой уулзах юм. Бага хурлаар ОУИТБС-ын дүрмийг шинэчлэн батлах ёстой. Мөн хурлын үеэр оролцогч орнуудын үзэсгэлэн зохион байгуулагдаж өөрсдийн үйл ажиллагаа улсаа суртчилах боломжтой болох юм. Түүнчлэн ОУИТБС-ын видеоны уралдааныг шалгаруулах арга хэмжээ болно. Хуралд оролцох төлөөлөгчид өөрсдийн байгууллагын суртчилгааны материалыг авч явах нь зүйтэй байх. Хурлын хөтөлбөрийг урьдчилан тараасан тул дэлгэрэнгүй мэдээллийг тэндээс харж болно.

Ч.Отгочулуу: Сиднэйн бага хурал дээр манай яамнаас баримталж байгаа байр суурь гэвэл: **нэгдүгээрт**, ОУИТБС-ын талаар Монгол улсад юу хийгдэж байна вэ? **хоёрдугаар**, тайлангийн зөрүүд хийсэн судалгааны талаар, **гуравдугаарт** ОУИТБС-ыг дэмжсэн хуультай болох гэж байгаа талаар тус тус танилцуулах төлөвлөөтэй байгаа.

Ш.Цолмон: 2013 оны 6 дугаар сарын 4-нд гадаад харилцааны яаман дээр тусгай арга хэмжээ болно. Энэ талаар Отгочулуу дарга танилцуулна.

Ч.Отгочулуу: Энэ арга хэмжээний урилга хөтөлбөрийг та бүхэнд тараасан байгаа. Товчхондоо, арга хэмжээг Уул уурхайн сайд Д.Ганхуяг нээж үг хэлнэ. Дараа нь Сиднэй бага хурлын талаар мэдээлэл, уул уурхайн салбарын өнөөгийн байдал зэрэг сэдвээр мэдээлэл хийж дараа нь ОУИТБС-ын хуулийн хэлэлцүүлэг болно. За би одоо хуралтай тул та бүхэн хурлаа үргэлжлүүлэхийг хүсье. Баярлалаа

Н.Баярсайхан: “Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлого” ын төслийг танай мэргэжилтэн Зууннаст явуулна гэсэн боловч одоо болтол авч чадаагүй байна. Үүнийг авч болох уу.

Ч.Отгочулуу: Үүнийг авч болно. Би ажлын алба руу имэйлээр явуулъя. Сургалтын хувьд гэвэл, уул уурхайн салбар маань тусдаа яамтай болчихлоо. Манай ашигт малтмалын газар дээр энэ чиглэлээр 2 хүн ажиллаж байна. Цаашид ч ажиллах хүч, орон тоо нэмэгдүүлэх бодлоготой байгаа. Иймд ил тод байдлын талаарх санал санаачилгыг олон нийтэд түгээх дэлгэрүүлэхэд сургалт семинар зайлшгүй шаардлагатай гэж үзээд бүрэн дэмжиж байна. За Хүрэлбат дарга сайдын айлчлалын талаар товч мэдээлэл өгнө.

Л.Долгормаа: Манай Засгийн газраас хариуцлагатай уул уурхайг дэмжиж ажиллана гэсэн. Энэ сургалтын хувьд хариулагатай уул уурхайн талаар төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудад зориулсан сургалтыг явуулах боломж байна уу?

Ч.Отгочулуу: Би сургалтыг бол дэмжиж байгаа. Энэ талаар та хэд ярилцаад тохирчих. Миний бодлоор бол аливаа юм оновчтой байх нь илүү үр дүнтэй байх болно гэж бодож байна.

Н.Алгаа: Энэ сургалт чинь өөрөө ил тод байдлын талаар гээд заачихсан байгаа.

Л.Долгомаа: Энэ төсөлд яамны зүгээс харуицлагатай уул уурхайн талаар оруулах боломжгүй юм гэсэн саналыг хэлэх гэсэн юм.

Н.Алгаа. Нэг зарчим нь ч гэсэн сайн хэрэгжээд явчихвал цаашдаа бас өөр юм хэрэгжүүлэхэд дөхөм болох байх л даа.

А.Хүрэлбат: Би товчхон ярья. Сайд ирэх 7 хоногт Сиднэй явна. Энэ айлчлал нь уул уурхайн сайдын тухайлсан орон руу явж байгаа анхны айлчлал байгаа. Австралийн уул уурхайн сайдын урилгаар явж байгаа. ОУИТБС-ын хуралд оролцоно. Австрали Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг гэж байдаг. Үүний 4 дэх удаагийн уулзалтад оролцоно. Олборлох салбарын ил тод байдалтай холбоотой хөтөлбөрийг тодорхой байгаа. Ажлын албанд танилцуулсан.

Ш.Цолмон: За тэгвэл саяны хүмүүсийн гаргасан саналуудыг нэгтгээд эцсийн байдлаар нэг төлөвлөгөөгөө явуулчих. Ингээд өнөөдрийн хурлаа өндөрлөө. Та бүхэнд баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Ажлын хэсгийн хурал 18 цагт 25 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн

А.Отгонтунгалаг